213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,705.18
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,693.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,488.40
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,205.18
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Тус сум 2022 онд “Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах” эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Толбо сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харьяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Толбо сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд шалгалт хийгдээгүй байна. Толбо сумын төсөвт байгууллагууд 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,343.0 сая төгрөгөөр буюу 66.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	231,540,191.94	225,922,765.94	(5,617,426.00)
Авлага	243,448,759.67	189,845,268.67	(53,603,491.00)
Бараа материал	286,123,636.59	64,766,380.00	(221,357,256.59)
Үндсэн хөрөнгө	4,284,561,597.47	1,222,129,933.32	(3,062,431,664.15)
Нийт хөрөнгө	<u>5,045,674,185.67</u>	<u>1,702,664,347.93</u>	<u>(3,343,009,837.74)</u>
Өр төлбөр	6702620.00	0.00	(6,702,620.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,038,971,565.67	1,702,664,347.93	(3,336,307,217.74)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>5,045,674,185.67</u>	<u>1,702,664,347.93</u>	<u>(3,343,009,837.74)</u>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэл 5.6 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 53.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Ажиллагсадтай холбоотой авлага 0.5 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 33.4 сая, хувь хүмүүсээс авах авлага 3.7 сая, зээлийн хүүгийн авлага 15.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Бараа материалын данс 221.4 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө данс 3,062.4 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны оны эхний 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж оны эцэст өр төлбөргүй гарсан байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд -3,309.0 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан, боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо дансанд 1,795.9 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд 2,017.1 сая төгрөгийн бууруулах бичилт, өмнөх үеийн үр түн дансанд 3,785.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх бичилт хийгдсэнтэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 3,336.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Толбо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,291.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,261.5 сая төгрөгийг урсгал зардалд, 30.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 991.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 200.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 100.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Толбо сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,085.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 857.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 200.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 16.7 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 10.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 16.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн ба үүнээс 16.0 сая төгрөг нь хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 0.7 сая төгрөг нь Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааны орлогоос байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн үндсэн үйл ажиллагааны орлого 83.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,047.6 сая төгрөг буюу 81.1 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Толбо сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 340.2 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 93 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор 377.5 сая төгрөгөөр буюу 57.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 50 дугаар тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг буюу малд ногдуулах албан татварыг 30.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 408.0 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 374.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 33.6 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар тасарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	402,732.90	325,336.20	-77,396.70	86.9
II.Татварын бус орлого	5,300.00	49,133.60	43,833.60	13.1
Нийт дүн	408,032.90	374,469.80	-33,563.10	100.00

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтээс орох орлого 27.3 сая, хөрөнгө борлуулсны орлого 5.7 сая, улсын тэмдэгтийн хураамж 7.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татвар хураамжийн орлого 1.7 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Татварын орлогоос үйл ажиллагааны орлого 53.9 сая, хөрөнгийн орлого 14.7 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1.0 сая, бууны албан татвар 0.9 сая, малд ногдуулах албан татвар 7.4 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 7.4 сая, газрын төлбөр 10.4 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 23.6 сая төгрөгөөр тус тус тасарсан нь төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

Татварын бус орлого 43.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 110.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 374.5 сая төгрөгийн татварын орлого оруулсан байна. Оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 67.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харъяа байгууллагууд 2022 онд 1291.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж 81.1 хувь буюу 1047.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Сум хөгжүүлэх санг, Орон нутгийн хөгжлийн сангуудын төлөвлөгөө тасарсан нь нөлөөлсөн байна. Төсөвт байгууллагууд батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулж төсөвт 3.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	74,058.60	73,753.51	-305.09
2	Сумын ЗДТГ	466,446.50	454,169.80	-12,276.70
3	Ерөнхий боловсролын сургууль	254,849.70	254,848.67	-1.03
5	Хүүхдийн цэцэрлэг	55,267.10	53,579.23	-1,687.87
8	Соёлын төв	32,348.30	27,542.57	-4,805.73
9	Эрүүл мэндийн төв	34,637.70	33,527.60	-1,110.10
10	ОНХСан	270,461.90	145,985.75	-124,476.15
11	СХС	100,000.00	834.30	-99,165.70
12	БОХС	3,904.10	3,404.10	-500.00
	Нийт дүн	1,291,973.90	1,047,645.53	-244,328.37

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 2.5 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 10.2 сая төгрөгийн нийт 12.7 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 1.5 сая, томилолтын зардалд 0.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 6.0 сая төгрөгийн нийтдээ 8.0 сая төгрөгийг зарцуулж, 4.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 03-ны өдрийн 1/54 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,841.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 38.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд бараа ажил, үйлчилгээний зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 7.4 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6.6 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 104.0 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 104.1 сая төгрөгөөр нийт 244.3 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 768.8 сая төгрөгийн 36 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 450.1 сая төгрөгийн 6 гүйлгээг, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 3.9 сая төгрөгийн 3 шийдвэрийг тус тус байршуулаагүй ба шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 51.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

ОНХСангийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1708.3 сая төгрөгийн 12 гүйлгээ хийгдсэнээс 71.9 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51.7 сая төгрөгийн зарлагын 8 гүйлгээ хийгдсэнээс 17.2 сая төгрөгийн 3 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 239.9 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 55.7 хувьтай байна.

СХСангийн цалингийн зардлаас бусад орлогын 15.9 сая төгрөгийн 20 гүйлгээ хийгдсэнийг мэдээлээгүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 0.8 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 50.0 хувьтай байна.

ОНХС-гийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1708.3 сая төгрөгийн 12 гүйлгээ хийгдсэнээс 71.9 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51.7 сая төгрөгийн зарлагын 8 гүйлгээ хийгдсэнээс 17.2 сая төгрөгийн 3 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 239.9 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 55.7 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, ОНХС, Хоршоог хөгжүүлэх сангуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад илэрсэн зөрчлийн дүнгээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Толбо сумын Засаг даргын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн улирал, сар бүр оруулах мэдээллийн 3,364.4 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаандаа байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, шилэн данстай холбоотой өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн ба тайлант онд биелэлтийг шалгахад хэрэгжээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгаж ажиллах талаар 1 заалттай зөвлөмж өгөгдсөний биелэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага	1	3,364.4	0	0	0%
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	1	3,364.4	1	0	50%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Толбо сумын Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 343.1 сая төгрөгийн залруулгын гүйлгээ хийгдсэн. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн дансыг 20.0 сая төгрөгөөр зөрүүтэй,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг 140.3 сая, үнэ төлбөргүй бараа материалыг 20.0 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих орлогыг 9.1 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлогыг 147.4 сая төгрөгөөр,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал болон үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн дүнг 2.5 сая, бусад орлогыг 3600 төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасныг залруулав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1222.8 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчлүүдэд тус тус албан шаардлага өгөв.Үүнд:

1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 768.8 сая төгрөгийн 36 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 450.1 сая төгрөгийн 6 гүйлгээг, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 3.9 сая төгрөгийн 3 шийдвэрийг тус тус байршуулаагүй ба шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 51.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.ОНХС-гийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.9 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17.2 сая төгрөгийн 3 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 239.9 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 55.7 хувьтай байна.

3.СХС-гийн цалингийн зардлаас бусад орлогын 15.9 сая төгрөгийн 20 гүйлгээ хийгдсэнийг мэдээлээгүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 0.8 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 50.0 хувьтай байна.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Байгаль хамгаалах сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 191.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 24.5 сая төгрөгийн залруулга хийгдэж, 166.6 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна. *Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/*

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Толбо сумын ИТХурал	1	14348.3							1	14348.3		
2	Толбо сумын ЗДТГазар	3	176796.7	1	24,500.0					2	152296.7		
	Дүн	4	191145	1	24,500.0	0	0	0	0	3	166,645.0	0	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн.	8	343063.6			8	343063.6	8	343063.6				
Дүн	8	343063.6			8	343063.6	8	343063.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		Тоо	Дүн
Дүн														

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 768.8 сая төгрөгийн 36 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 450.1 сая төгрөгийн 6 гүйлгээг, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 3.9 сая төгрөгийн 3 шийдвэрийг тус тус байршуулаагүй	1	1,222,809.6			1	1,222,809.6		
ОНХС - 71,953.5 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй, 17250.0 мянган төгрөгийн 3 гүйлгээний	1	329,165.5			1	329,165.5		

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мэдээллийг байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 239,961.9 мянган төгрөгийн 1 шийдвэр гарсныг мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 55.7 хувьтай байна							
СХС-цалингийн зардлаас бусад орлогын 15,981.3 мянган төгрөгийн 20 гүйлгээ хийгдсэнийг мэдээлээгүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 834.3 мянган төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 50.0 хувьтай байна	1	16,815.6			1	16,815.6	
Дүн	3	1,568,790.7			3	1,568,790.7	
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн	3	1,568,790.7			3	1,568,790.7	